



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Халиун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/03/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор

Утас: 70484030

Б.Цэвэлмаа

Цахим хаяг: tsevelmaab@audit.gov.mn



Г ХАЛИУН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.МЯНГАНБАЯР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 122

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Халиун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Халиун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Олонбулаг Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор тус хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702000284

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

мянган төгрөгөөр

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,201,788.80	798,574.20
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,300,711.70	1,038,712.10
	Нийт хөрөнгийн дүн	4,502,500.50	1,837,286.30
	Нийт өр төлбөрийн дүн	11,132.30	1,452.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,491,368.10	1,835,834.40
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,502,500.40	1,837,286.40
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,728,268.60	1,278,764.10
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,507,087.70	1,033,864.00
	Үйл ажиллагааны үр дүн	221,180.90	244,900.10
	Үйл ажиллагааны бус үр дүн	194,389.60	2,764,243.80
	Үйл ажиллагааны нийт үр дүн	26,791.30	-2,519,343.70
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,466,077.40	4,491,368.20
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,500.60	-136,190.10
	Тайлант оны үр дүн	26,791.40	-2,519,343.60
	Эцсийн үлдэгдэл	4,491,368.20	1,835,834.50
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,256,904.50	1,245,362.50
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,044,651.10	942,475.60
	Үйл ажиллагааны ЦМГ	212,253.40	302,886.90
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-182,201.80	-291,448.20
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-64,200.00	-11,000.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-34,148.40	438.70
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	215,618.70	181,470.20
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	181,470.20	147,371.80
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,377,502.20	1,311,735.40
	Урсгал зардал	2,158,832.30	938,351.70
	Хөрөнгийн зардал	138,169.90	359,547.40
	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	80,500.00	13,836.30
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,377,502.20	1,311,735.40
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,360,609.50	
	Орон нутгийн төсвөөс	774,048.70	1,038,331.20
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	53,276.60	150,347.90
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	24,174.10	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	165,393.30	123,056.30

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.3 сая төгрөгийн алдаа , зөрчлийг арилгасан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн барьцаа хөрөнгө 0.3 сая төгрөгийг татварын орлогоор тайлагнасан, хоршоо хөгжүүлэх сангийн аудитлагдсан тайланг нэгтгэсэн тайланд 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн байна.

Аудитаар нийт 7.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 7.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 0.2 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 2.7 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.8 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.5 төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 1.1 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" Халиун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 35 дугаар тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Нэгж байгууллагуудад 2.1 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Халиун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 35 дугаар тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Халиун сумын ТТЗ	2	0.9			2	0.9	2	0.9				
Халиун сумын Засаг даргын Тамгын газар	1	132.0			1	132.0	1	132.0				
Халиун сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	3.4			1	3.4	1	3.4				
Халиун сумын ОНХС	1	208.1			1	208.1	1	208.1				
Дүн	5	344.3	-	-	5	344.3	5	344.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Халиун сумын ТТЗ	1	2.1			1	2.1						
Халиун сумын Засаг даргын Тамгын газар	11	52.3	3.0	24.1	6.0	27.2	1	1	1	1		
Халиун сумын ИТХ	2	3.6	2.0	3.6								
Халиун сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	2.7	1.0	2.7								
Халиун сумын ОНХС	2	165.7			2.0	165.7						
Дүн	17	226.4	6.0	30.4	9.0	195.0	1	1	1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Халиун сумын Засаг даргын тамгын газар	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	0	0	0	0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Халиун сумын Засаг даргын тамгын газар	1	-	-	-	-	-	1	-
Халиун сумын ТТЗ	1	5.4				1	5.4	
Дүн	2	5.4	0	0	0	1	5.4	0
Нийт дүн	3	5.4	0	0	0	1	5.4	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Халиун сумын ТТЗ	1	1	-	-	1	-	-	-
2	Халиун сумын ЗДТГ	1	1				1		
3	Халиун сумын ИТХ	1		1					
4	Халиун сумын Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Халиун сумын ОНХС	1		1					
6	Халиун сумын Олонбулаг ЕБС	1		1					
7	Халиун сумын БХНСС	1		1					
	НИЙТ	7		5		1	1	-	-